

## ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ТУШААЛ

2019 оны ... дугаар  
сарын ... -ны өдөр

Дугаар

Улаанбаатар  
хот

Монгол улсын 2020 онд экспортлох, импортлох стратегийн  
хүнсний нэр, төрөл, тоо хэмжээг тогтоох тухай

Хүнсний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7 дахь хэсэг, Хүнсний аюулгүй байдлын Үндэсний зөвлөлийн 2019 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдааны 03 зөвлөмжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем”-д үндэслэн гадаад худалдааны барааны ангиллын жагсаалтад нийцүүлэн 2020 онд экспортлох стратегийн хүнсний нэр, төрөл, тоо хэмжээг 1 дүгээр, импортлох стратегийн хүнсний нэр, төрөл, тоо хэмжээг 2 дугаар хавсралтад заасны дагуу тус тус тогтоосугай.

2. Стратегийн хүнсийг экспортлох зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтыг “Стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрөл олгох журам”-ын дагуу зохион байгуулахыг ажлын хэсэг /Т.Гантогтох/-т, зөвшөөрлийг хууль, тогтоомж, энэхүү тушаалд нийцүүлэн олгож ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Т.Жамбалцэрэн/-д тус тус даалгасугай.

3. Тушаалыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэн, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх арга хэмжээ авахыг Хуулийн хэлтэс /Э.Цолмонжаргал/-т үүрэг болгосугай.

САЙД

Ч.УЛААН

Төсөл  
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын  
2019 оны ... дугаар сарын ...-ны өдрийн ... дугаар  
тушаалын 1 дүгээр хавсралт

**2020 ОНД ЭКСПОРТЛОХ СТРАТЕГИЙН ХҮНСНИЙ НЭР ТӨРӨЛ,  
ТОО ХЭМЖЭЭ, АНГИЛЛЫН КОД**

№	Стратегийн хүнсний нэр	Төрөл	БТКУС-ын код	Нийт тоо, хэмжээ
1	Үхрийн мах	Үхрийн гулууз болон өрөөл шинэ эсхүл хөргөсөн мах	0201.10.00	8300 тн (найман мянга гурван зуу)
2		Үхрийн ястай нь хэсэглэсэн шинэ эсхүл хөргөсөн мах	0201.20.10	
3		Үхрийн ясгүй хэсэглэсэн, шинэ эсхүл хөргөсөн мах	0201.30.10	
4		Үхрийн гулууз болон өрөөл, хөлдүү мах	0202.10.00	
5		Үхрийн ястай нь хэсэглэсэн, хөлдүү мах	0202.20.10	
6		Үхрийн ясгүй хөлдүү мах	0202.30.10	
7		Сарлагийн ястай нь хэсэглэсэн шинэ эсхүл хөргөсөн мах	0201.20.20	
8		Сарлагийн ясгүй шинэ эсхүл хөргөсөн мах	0201.30.20	
9		Сарлагийн ястай хөлдүү мах	0202.20.20	
10		Сарлагийн ясгүй хөлдүү мах	0202.30.20	
11	Адууны мах	Адууны ястай шинэ, хөргөсөн, хөлдүү мах	0205.00.11	27900 тн (хорин долоон мянга есөн зуу)
12		Адууны ясгүй (шулсан) шинэ, хөргөсөн, хөлдүү мах	0205.00.12	
13	Дулааны аргаар боловсруулсан мах	Үхрийн мах	1602.50.00	8000 тн (найман мянга)
		Хонины мах	1602.90.00	6600 тн (зургаан мянга зургаан зуу)
		Ямааны мах	1602.90.00	12000 тн (арван хоёр мянга)

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын  
2019 оны ... дугаар сарын ...-ны өдрийн ... дугаар  
тушаалын 2 дугаар хавсралт

2020 ОНД ИМПОРТЛОХ СТРАТЕГИЙН ХҮНСНИЙ НЭР ТӨРӨЛ,  
ТОО ХЭМЖЭЭ, АНГИЛЛЫН КОД

№	Стратегийн хүнсний нэр	Төрөл	БТКУС-ын код	Нийт тоо, хэмжээ
1	Үхрийн мах	Үхрийн гулууз болон өрөөл шинэ эсхүл хөргөсөн мах	0201.10.00	500 тн (таван зуу)
2		Үхрийн ястай нь хэсэглэсэн шинэ эсхүл хөргөсөн мах	0201.20.10	
3		Үхрийн ясгүй хэсэглэсэн, шинэ эсхүл хөргөсөн мах	0201.30.10	
4		Үхрийн гулууз болон өрөөл, хөлдүү мах	0202.10.00	
5		Үхрийн ястай нь хэсэглэсэн, хөлдүү мах	0202.20.10	
6		Үхрийн ясгүй хөлдүү мах	0202.30.10	
7	Хуурай сүү	Хуурай сүү	0402.21.10	4000 тн (дөрвөн мянга)
8	Улаанбуудай	Үрийн хатуу улаанбуудай	1001.11.00	15000 тн (арван таван мянга)
9		Үрийн зөөлөн улаанбуудай	1001.91.10	
10		Улаанбуудай, хүнсний	1001.19.00	60000 тн (жаран мянга)

/улаанбуудайн кодыг дахин нягтлах/